



ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 42

Хэрлэн сум

Нийгмийн даатгалын газрын Галшар  
сумын Нийгмийн даатгалын байцаагчийн  
сул орон тоонд томилуулахаар  
нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо (69,25) авсан Эрдэнэбаатарын Нанжидмааг Нийгмийн даатгалын газрын Галшар сумын Нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2.Нэр дэвшигч Э.Нанжидмааг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Нийгмийн даатгалын газрын дарга (Н.Нямхатан)-д зөвлөсүгэй.

3.Энэхүү тогтоолыг Нийгмийн даатгалын газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА

